

## НИЙСЛЭЛИЙН НАЛАЙХ ДҮҮРЭГ



# ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

/Албан ёсны статистик мэдээллээр бэлтгэв./

2015 оны 2-р сар

СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

## АГУУЛГА

	<i>Хуудасны дугаар</i>
 ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ	2-3
 ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ	4
 АЖ ҮЙЛДВЭР	5
 НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ	6
 АЖИЛ ЭРХЛЭЛТ	7
 ЭРҮҮЛ МЭНД, ИРГЭНИЙ БҮРТГЭЛ	8-9
 МЭДЭЭЛЭЛ, ХОЛБОО	10
 АЮУЛГҮЙ БАЙДАЛ	11
 ГЭМТ ХЭРЭГ	12-13



### НАЛАЙХ ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЖИЛ БҮРИЙН 2-Р САРЫН БАЙДЛААР

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2013 он	2014 он	2015 он
Суурин хүн ам, оны эцэст	хүн	33235	34547	-
Шинээр төрсөн хүүхэд	хүүхэд	156	138	125
Ажилгүйчүүд, сарын эцэст	хүн	1460	893	730
үүнээс: эмэгтэй	хүн	818	486	371
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн	хүн	158	59	122
Бүртгэсэн гэмт хэрэг	тоо	42	52	70

### НИЙСЛЭЛИЙН ДҮҮРГҮҮДИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДЛЫН ХАРЬЦУУЛСАН ҮЗҮҮЛЭЛТ:

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2014 оны 2-р сарын байдлаар					2015 оны 2-р сарын байдлаар				
		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага	
Хүн амын нягтрал /1км <sup>2</sup> -т ногдох хүн/	тоо	271	Баянгол	6816	<b>Налайх</b>	<b>49</b>	281	Баянгол	7111	<b>Налайх</b>	<b>5</b>
			Чингэлтэй	1754	Багануур	45		Чингэлтэй	1795	Багануур	4
			Сүхбаатар	643	Багахангай	27		Сүхбаатар	658	Багахангай	2
Ажилгүйчүүд /хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох/	01000*	141	<b>Налайх</b>	<b>376</b>	Баянзүрх	129	163	<b>Налайх</b>	<b>421</b>	Баянгол	16
			Багахангай	288	Хан уул	128		Багахангай	324	Баянзүрх	10
			Сүхбаатар	153	Сонгинохайрхан	128		Багануур	249	Сонгинохайрхан	8
Нялхсын нас баралт /амьд төрсөн 1000 хүүхдэд/	0100	16	Багахангай	91	Баянгол	11	15	Баянзүрх	16	Чингэлтэй	6
			<b>Налайх</b>	<b>29</b>	Сонгинохайрхан	11		Хан –Уул	15	<b>Налайх</b>	-
			Хан-Уул	23	Сүхбаатар	10		Сүхбаатар	14	Багахангай	-
10000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчлөгсөд	01000*	20	Баянзүрх	20	Сонгинохайрхан	13	20	Багануур	44	Баянгол	1
			Багануур	20	Баянгол	12		<b>Налайх</b>	<b>37</b>	Сүхбаатар	1
			Чингэлтэй	19	Багахангай	5		Чингэлтэй	20	Багахангай	-
Төсвийн орлого, зарлагын харьцаа зарлага=100	мян.т өг	162	Сүхбаатар	168	Баянгол	126	122	Чингэлтэй	152	Багануур	8
			Хан-Уул	161	Багахангай	125		Сүхбаатар	150	<b>Налайх</b>	8
			Чингэлтэй	154	<b>Налайх</b>	<b>121</b>		Хан-Уул	119	Багахангай	6
18-аас дээш насны 10000 хүнд ногдох гэмт хэрэг	тоо	31	Сүхбаатар	44	Сонгинохайрхан	25	38	Сүхбаатар	64	Сонгинохайрхан	2
			Баянгол	33	<b>Налайх</b>	<b>23</b>		Чингэлтэй	42	Хан –Уул	2
			Чингэлтэй	33	Багахангай	8		Баянзүрх	42	Багахангай	1

## Дүүргийн хороодын хэсэг, байршлаар:

Хорооны дугаар	Хэсгийн дугаар	Хэсгийн байршил	Хэсгийн өрхийн тоо	Өрхийн дундач хүн ам
1-р хороо	1	“Өндөр настан”-1а, “Уурхайчид” 1-5-р гудамж	224	4,3
	2	“Уурхайчид” 6-13-р гудамж	232	3,7
	3	“Уурхайчид” 14-21-р гудамж	195	4,0
	4	“Уурхайчид” 22-32-р гудамж	172	3,7
	5	“Баянзүрх” 1-7-р гудамж	236	4,0
	6	“Баянзүрх” 8-19-р гудамж	174	5,4
	7	“Энгэршанд” 1-24-р гудамж, хөдөөгийн хэсэг	302	3,1
2-р хороо	1	1-9-р байр, “Соёл” гудамж	187	3,1
	2	10-22, 88-р байр, “Жаргалант”-1,	164	3,7
	3	23-32-р байр	155	3,2
	4	24а, 31а,б, 33, 40, 41-р байр, “Уурхайчин”-1, “Дамдин”, “Тун хаш” гудамж	195	3,4
	5	35-р байрны 3,4-р орц, 36,37-р байр	185	3,1
	6	35-р байрны 1,2-р орц, 38,39-р байр, “Уурхайчин-2” гудамж	207	3,6
	7	42-47-р байр	194	3,3
	8	48-53-р байр “Наадам”-1,2-р гудамж	218	3,5
	9	54-59-р байр	194	3,1
	10	60-67-р байр	217	3,1
	11	“Нарлаг”-1-25-р гудамж	218	4,9
	12	“Уурхайчин”-1, “Тайж”-1-24-р гудамж	216	3,3
3-р хороо	1	“Замчин” 1-24-р гудамж, Төмөр замын орон сууц-1-6-р байр	302	4,1
	2	“Замчин” 25-41-р гудамж	262	3,5
	3	“Дэнж” 1-9, 19-р гудамж,	162	3,4
	4	“Дэнж” 10-18, 21, 22-р гудамж	173	3,6
	5	“Наран” 1-16-р гудамж	230	3,6
	6	“Наран” 17-36-р гудамж, “Батцэцэг”-тоосго,	246	3,2
	7	4-р зөрлөг, “Замчин” 42-52-р гудамж, “Баянбүрд”, “Хөндлөн”, “Шохойт”, “Локатор”, “Тайж”	129	3,3
4-р хороо	1	“Өлгий” 1-9-р гудамж	145	4,4
	2	“Туул” 12-26-р гудамж	151	4,0
	3	“Туул” 1-11-р гудамж	163	3,8
	4	“Алтай” 1-7-р гудамж	181	4,0
	5	“Алтай” 8-12-р гудамж	195	4,2
	6	“Нисэх” 1-6-р гудамж	211	3,9
	7	“Нисэх” 7-23-р гудамж	223	3,9
	8	“Бүс нуур” 1-8-р гудамж, “Их ам” 1-27-р гудамж, “Нисэх” 11“а-д”-р гудамж	248	3,8
	9	“Подстанц”, “Ус суваг”, “Нисэх” 24-60-р гудамж	174	3,4
5-р хороо	1	“Гандан уул” 1,1“а-з”, 2-р гудамж	124	3,4
	2	“Гандан уул” 3-6-р гудамж	145	3,1
	3	“Гандан уул” 7-12, 17-р гудамж	104	3,3
	4	71, 75, 76, 77-р байр	97	3,3
	5	70, 72, 78, 79-р байр	132	3,0
	6	“Аржанчивлан”, 74, 80-р байр	161	2,9
	7	“Гандан ам” 1-3-р гудамж, “Уу булан”, “Өндөр улаан”, “Шохой”,	111	3,1
6-р хороо	1	“Тэрэлж төв”- 1-99 тоот, “Усан сан” 1-6-р гудамж, “Шилжрээ” 1-6-р гудамж,	216	2,7
	2	“Тэрэлж шугуй” 46, “Дуган цагаан” 1-9, “Тасын тохой” 1-3, “Чандрууны булан” 1-5, “Дэлгэр дэв” 1-9, “Бугат” 1-5, “Өлийн булан” 1-9, “Шар булаг” 1-56, “Рам”, “Зөгий”, “Баян” 1-2 тоот	196	2,5
	3	“Мэлхий хад” 1-3, “Сан” 1-3, “Өгөөмөр” 1-9, “Бүүвэйт” 1-10, “Нарлаг” 1-10, “Жавхлант” 1-9, “Жүдийн хонд” 1-3, “Оранж” 1-3, “Онгод” 1-5, “Зурхайч” 1-9 тоот	84	2,3
	4	“Ар хүүш” 1-6, “Болор” 1-7, “Эрээний адаг” 1-29, “Бумбагар хад” 1-3, “Гялалзах” 1-3, “Мөнхжин” 1-3, “Полигон” 1-5, “Хөндлөн” 1-5, “Тогоочийн булаг” 1-9, “Баян цагаан” 1-2, “Өндөр улаан” 1-2 тоот	92	2,3
7-р хороо	1	75-р байр, “Хийд” 1, “Бадрал” 1-5-р гудамж	261	3,6
	2	“Бадрал” 6-11-р гудамж	182	4,9
	3	“Бадрал” 12-22-р гудамж	202	3,7
	4	“Өвөршанд” 4а-9а, “Өвөршанд” 1-7-р гудамж	175	3,0
	5	“Өвөршанд” 8-14-р гудамж	204	3,4
	6	“Өвөршанд” 15-20-р гудамж	175	3,3
<b>ДҮН</b>	<b>52 хэсэг</b>		<b>9755</b>	<b>3,6</b>



## ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ

Түүхий эдийн нэр	2014	2015
	2-р сар	2-р сар
Тэмээний шир	18000	22000
Адууны шир	32000	45000
Үхрийн шир	41000	52000
Хонины арьс	6500	4500
Ямааны арьс /ноолууртай/	27000	25000



Түүхий эдийн үнэ өмнөх оны мөн үеэс тэмээний шир 4000 төгрөгөөр буюу 22,2%-иар, адууны шир 13000 төгрөгөөр буюу 40,6%-иар, үхрийн шир 11000 төгрөгөөр буюу 26,8%-иар тус тус өсч, харин хонины арьс 2000 төгрөгөөр буюу 30,8%-иар, ямааны ноолууртай арьс 2000 төгрөгөөр буюу 7,5%-иар тус тус буурсан байна.

### Түлшний үнэ, төгрөгөөр:

Байршил	Түлшний мод шуудай / 6-7 кг/		Нүүрс /Налайх/ /12-14кг/
	Хар мод	Нарс мод	
Налайх	1120		1400
Чингэлтэй	1200		2100
Сүхбаатар	1200		2200
Цайз зах	1000		2000
Хангай зах	1000	900	2000
Дундаж үнэ	1104	900	1940

### Шатахууны үнэ -1 литр /төгрөгөөр/

ААН-ийн нэр	Аи95	Аи80	Аи92	Мон 93	Дизель тулш	Газ
Жаст Ойл ХХК	1890	1550	1660		1790	
Петровис ХХК	1890	1550	1660	1660	1790	
Магнай трейд ХХК	1890	1550	1660		1790	
Сод Монгол ХХК	1890	1550	1660		1790	
Шунхлай ХХК		1550	1660		1790	
ЮниГаз ХХК						1400
Дундаж үнэ	1890	1550	1660	1660	1790	1400

**АЖ ҮЙЛДВЭР**

2015 оны эхний 2 сарын байдлаар 2596379.6 мянган төгрөгийн борлуулалт хийсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад борлуулалт 26,4 хувиар өссөн байна. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өнгөрсөн онтой харьцуулахад уул уурхайн олборлох салбарын үйлдвэрлэлт 23,3 хувиар, дулаан 59,7 хувиар, эрчим хүч 19,9 хувиар тус тус өсч, боловсруулах үйлдвэр 37,3 хувиар усан хангамжийн үйлдвэрлэлт 1,2 хувиар тус тус буурсан байна.

**Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл, өссөн дүнгээр:**

Салбараар	Нийт бүтээгдэхүүн		
	2014 оны 2-р сар	2015 оны 2-р сар	<u>2015</u> 2014
Уул уурхай олборлох үйлдвэр	1.2	1.2	100.0
Нүүрс олборлолт /мян.тн/	1.2	1.2	100.0
Элс олборлолт /мян.мЗ/	-	-	-
Хайрга олборлолт / мян.мЗ/	-	-	-
Шохойн чулуу олборлолт /мян.мЗ/	-	-	-
<b>Боловсруулах үйлдвэр</b>	10.8	5.5	50.9
<b>Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл</b>	3.2	3.1	96.9
Талх /мян.ш/	3.2	3.1	96.9
Хувцас үйлдвэрлэл /мян.ш/	2.6	2.4	92.3
Тоосго үйлдвэрлэл /мян.ш/	5.0	-	-
<b>Цахилгаан, дулаан, усан хангамж</b>			
Цахилгаан мян.кВт.ц	14460.4	15057.2	104.1
Дулаан үйлдвэрлэл /төг.Гкал/	32110.0	37965.9	118.2
Ус ариутгал, усан хангамж	310.3	229.2	73.9

**Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний борлуулалт, өссөн дүнгээр/мян төгрөг/:**

Салбараар	Нийт бүтээгдэхүүн		
	2014 он 2 сар	2015 он 2 сар	<u>2015%</u> 2014
Уул уурхай олборлох үйлдвэр	46600.0	57440.0	123.3
Нүүрс олборлолт	46600.0	57440.0	123.3
Элс олборлолт	-	-	-
Хайрга олборлолт	-	-	-
Шохойн чулуу олборлолт	-	-	-
<b>Боловсруулах үйлдвэр</b>	23772.7	14900.0	62.7
<b>Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл</b>	<b>3000.0</b>	<b>2900.0</b>	<b>96.7</b>
Талх	3000.0	2900.0	96.7
Хувцас үйлдвэрлэл	20000.0	12000.0	60.0
Тоосго үйлдвэрлэл	772.7	-	-
<b>Цахилгаан, дулаан, усан хангамж</b>	1983270.2	2524039.6	127.3
Цахилгаан	1484793.5	1781034.0	119.9
Дулаан үйлдвэрлэл	411281.7	656847.6	159.7
Ус ариутгал, усан хангамж	87195.0	86158.0	98.8
<b>ДҮН</b>	<b>2053642.9</b>	<b>2596379.6</b>	<b>126.4</b>




## НИЙГМИЙН ДААТГАЛ

2015 оны эхний 2 сард нийгмийн даатгалын үйлчилгээнд 965,8 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийн орлого оржээ.

Нийт шимтгэл төлөгчдийн 35,0 хувь буюу 338,1 сая төгрөг нь аж ахуйн нэгж, байгууллага, 52,3 хувь буюу 504,8 сая төгрөг нь төсөвт байгууллага, 4,2 хувь буюу 40,4 сая төгрөг нь эрүүл мэндийн даатгал, 7,0 хувь буюу 67,5 сая төгрөг нь сайн дурын даатгуулагчдыг байна.

Нийгмийн даатгалын сангаас энэ сард 14820 даатгуулагч, иргэнд 1658,8 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, эмчилгээний зардал, эмийн үнийн хөнгөлөлт олгосон байна.

### Даатгалын сангийн зарлага:



Нийт зардлын 65,3 хувийг тэтгэвэр, 13,0 хувийг YOMШӨ, 1,9 хувийг тэтгэмж, 0,9 хувийг ажилгүйдэл, 18,9 хувийг эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон зардал эзэлж байна.

Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагч иргэдийн тоо 2-р сард 4195, олгосон тэтгэврийн хэмжээ 1083,7 сая төгрөгт хүрчээ.

Олгосон нийт тэтгэврийн 81,8 хувийг өндөр насны, 13,3 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 5,6 хувийг тэжээгчээ алдсаны тэтгэвэрт зарцуулсан байна.



## НИЙГМИЙН ХАЛАМЖ

2015 оны эхний 2 сард давхардсан тоогоор нийт 7275 хүнд 727,1 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.

№	Үзүүлэлтүүд	Хүний тоо	Дүн /мян.төг/
1	Халамжийн орлого /бүгд/	-	867291,6
2	Зарцуулалт бүгд	7275	727087,1
3	Үүнээс: Халамжийн тэтгэвэр	867	195467,6
4	Нөхцөлт мөнгөн тэтгэмж	496	64487,7
5	Иргэнд үзүүлэх хөнгөлөлт	12	24473,0
6	Халамжийн үйлчилгээ	45	1987,2
7	Ахмад настны хөнгөлөлт	2390	58894,2
8	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд	268	9103,4
9	Эхчүүдийн мөнгөн тэтгэмж	1031	80064,2
10	Алдарт эхийн одонгийн тусламж	2157	288260,0
11	Алдар цолтой ахмадуудад	9	4350,0

2014 оны жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор 12435 хүнд 2839386.8 мянган төгрөгийн халамжийн тэтгэмж, тусламж, хөнгөлөлт үзүүлсэн байна.



## ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ

Дүүргийн хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо 2015 оны 2-р сарын эцэст 730 болж, өмнөх оны мөн үеэс 22,3 хувь буюу 163 хүнээр буурчээ. Нийт ажилгүйчүүдийн 371 буюу 50,8 хувь нь эмэгтэйчүүд байна.

2015 оны 2-р сард ажилгүй 222 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй ажилгүй байсан 1 иргэн ажилд зуучлагдан төрийн байгууллагад ажилд орж, 274 иргэн бүртгэлээс хасагджээ.

### Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо, насны бүлгээр:

Насны бүлэг	2014 он	2015 он
Бүгд	893	730
эмэгтэй	486	371
Бүгд 15-24	204	145
эмэгтэй	94	68
Бүгд 25-34	35	246
эмэгтэй	206	139
Бүгд 35-44	226	175
эмэгтэй	130	93
Бүгд 45-54 дээш	99	125
эмэгтэй	52	58
Бүгд 55-59 дээш	8	23
эмэгтэй	4	8
Бүгд 60+ дээш	1	16
эмэгтэй	0	5
Бүгдээс : Хөгжлийн бэрхшээлтэй	22	20

### Бүртгэлтэй ажилгүйчүүд, боловсролын түвшнээр:

Үзүүлэлт	Ажилгүйчүүдийн тоо		Дүнд эзлэх хувь	
	2014 он	2015 он	2014 он	2015 он
Нийт ажилгүйчүүд	893	730	100.0	100.0
Үүнээс: дээд боловсролтой	94	103	10.5	14.1
Тусгай дунд боловсролтой	44	54	4.9	7.4
Мэргэжлийн анхан шатны Боловсролтой	145	98	16.3	13.4
Ерөнхий боловсролтой	605	466	67.7	63.9
Мэргэжилгүй	5	9	0.6	1.2





### ЭРҮҮЛ МЭНД

2015 оны эхний 2 сарын байдлаар 125 эхийн 125 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оноос 13 хүүхдээр буурсан байна. Нийт нас баралтын 24 буюу 75,0 хувийг гэрийн нас баралт, 8 буюу 25,0 хувийг эмнэлгийн нас баралт эзэлж байна.

#### Төрсөн хүүхэд, эх, хүүхдийн эндэгдэл:

Үзүүлэлт	2014 он	2015 он	$\frac{2015}{2014}$ %
Амаржсан эхийн тоо	139	125	89.9
Амьд төрсөн хүүхэд	138	125	90.6
Эхийн эндэгдэл	-	-	-
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	4	-	-
Амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	28.7	-	-
Нас баралт	43	32	74.4
Халдварт өвчин	18	21	116.7
Арьс өнгөний өвчин	41	101	246.3
Сүрьеэ	3	9	300.0

Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 19 буюу 90.5 хувийг салхинцэцэг, 2 буюу 9.5 хувийг дезинтери Арьс өнгөний өвчнөөр өвчлөгсдийн 28 буюу 27.7 хувийг тэмбүү, 14 буюу 13.9 хувийг трихомониаз, 33 буюу 32.7 хувийг мөөгөнцөр өвчнөөр өвчлөгсөд тус тус эзэлж байна.

#### ИРГЭНИЙ БҮРТГЭЛ

##### Төрөлт, нас баралт, гэрлэлт, гэр бүл цуцлалт, үрчлэлтийн бүртгэл:

		2014	2015
<b>Төрсөн Бүгд</b>	<b>хүүхэд-</b>	<b>128</b>	<b>135</b>
Үүнээс:	-эрэгтэй	63	70
	-эмэгтэй	65	65
<b>Нас баралт -Бүгд</b>		<b>39</b>	<b>38</b>
Үүнээс:	-эрэгтэй	21	25
	-эмэгтэй	18	13

2015 оны эхний 2 сард 135 хүүхдийг иргэний бүртгэлд бүртгэн, нас барсан 38 хүнийг иргэний бүртгэлээс хасч, 22 гэрлэлтийг бүртгэж, 10 гэр бүлийг цуцалсан байна. Төрсөн хүүхдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад ижил байна.

Харин нас баралт өнгөрсөн оны мөн үеийнхээс 1 буюу 2,6%-аар буурсан байна.

**Гэр бүл цуцлалт:**

		2014	2015
<b>БҮГД</b>		<b>8</b>	<b>10</b>
Гэр бүл байсан хугацаагаар /жилээр/	1 хүртэл	-	-
	1-3	-	2
	4-6	2	1
	7-9	2	5
	10-14	-	1
	15-19	1	1
	20 ба дээш	3	-

Гэр бүл цуцлалт 2 буюу 50,0 %-аар өсч, гэрлэлт 9 буюу 45,0 %-аар буурсан байна.

Нийт 10 гэр бүлийн цуцлалт байгааг гэр бүл байсан хугацаагаар нь ангилбал 20,0% нь 1-3 жил, 50,0 % нь 7-9 жил, 30,0% нь 4-6 жил, 10-14, 15-19 жил хангилсан хосууд байна.

Гэр бүл цуцлалт нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 25%-иар өссөн байна

**Бүртгүүлсэн гэр бүл:**

<b>Бүгд</b>		2014		2015	
		Эр	Эм	Эр	Эм
		<b>36</b>	<b>36</b>	<b>22</b>	<b>22</b>
Насны бүлгээр	18-19	-	1	-	1
	20-24	8	15	6	8
	25-29	17	9	10	10
	30-34	5	6	4	1
	35-39	3	4	-	1
	40-44	2	1	2	1
	45-49	-	-	-	-
	50, +	1	-	-	-

Нийт 22 бүртгүүлсэн гэр бүлийг насаар ангилбал 4,5% нь 18-19 насны, 36,4% нь 20-24, 45,4% нь 25-29 насны, 13,7% нь бусад насны хосууд байна.

Бүртгүүлсэн хосуудыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 38,8%-иар буурсан байна.

**Үрчлэлт:**

		2014	2015
<b>БҮГД</b>		<b>2</b>	<b>4</b>
насаар	3 хүртэл	1	1
	3-6	-	1
	7-9	-	1
	10 ба дээш	1	1

2015 оны эхний 2 сард 4 хүүхэд үрчлэгдсэн байна.

“Налайх дүүргийн эдийн засаг, нийгмийн байдал” статистикийн 2015 оны 2-р сарын танилцуулга

**СҮМ ХИЙДИЙН ТООЛЛОГЫН ДҮН** /2014 оны 11 сарын тооллогын дүнгээр/

	Үүнээс, шашны төрлөөр:	Будда		Христ		Ислам	Дүн
		3		11		2	16
Дүүрэгт нийт 16 сүм, хийд үйл ажиллагаа явуулж байна.	Зөвшөөрөлтэй:	2		2		1	5
	Зөвшөөрөлтэй сүм, хийд шашны урсгалаар:	Шарын гэлүгла	Улааны нямава	Протестант	Бусад	“Коняа соёлын төв” хэлбэр	5
		1	1	1	1		
	Зөвшөөрөлгүй:	1		9		1	11
	Статистикийн мэдээ өгдөг:	2		2		1	5
	Сүм хийдэд ажиллагсад:	17		6		3	26
	Сайн дурын ажиллагсад:	14		4		-	18
	Үүнээс, байрны эзэмшлээр:	Өөрийн эзэмшил		Түрээс		Бусад	
		12		1		3	16




**МЭДЭЭЛЭЛ, ХОЛБОО**

Холбооны орлого 2015 оны эхний 2 сард 32958.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 5319.2 мянган төгрөгөөр буюу 19.2 хувиар өсчээ. Нийт орлогын 49,0 хувь буюу 16149.5 мянган төгрөгийг дүүргийн хүн амд үзүүлсэн үйлчилгээнээс бүрдүүлсэн байна.

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2014 оны 2-р сар	2015 оны 2-р сар
Нийт орлого	мян төг	27638.9	32958.1
Үүнээс: хүн амаас	мян төг	16583.9	16149.5
Суурин телефон цэг	тоо	712	640
Үүнээс: айл өрхийн	тоо	442	370
Интернет цэг	тоо	2	2
Интернетээр үйлчлүүлэгчийн тоо	тоо	3599	4010

2015 оны эхний 2 сард дүүргийн хэмжээнд суурин телефон цэгийн тоо 640 болж, өмнөх онтой харьцуулахад 10,1 хувиар буурсан байна. Нийт суурин телефон цэгийн 370 буюу 57.8 хувийг айл өрх ашиглаж байна.

**Суурин телефон цэгийн тоо:**



**АЮУЛГҮЙ БАЙДАЛ**


Гамшиг, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх үзлэгийг хийж, нийт 860 гаруй айл өрхөөс 80 зөрчил, 64 аж ахуйн нэгж, байгууллагаас 452 зөрчил илрүүлэн, 200 ширхэг сэрэмжлүүлэх хуудас тарааж, 29 зөрчлийг арилгуулан, гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 27, мэдээгдэл 23, ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт 4-г хүргүүлсэн байна.

Засаг даргын Тамгын газар, Мэргэжлийн хяналтын хэлтэс, Цагдаагийн хэлтэс хамтран уурхайн эдэлбэр газарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, хувиараа нүүрс олборлогч иргэний нийт 39 цооногт үзлэг шалгалт хийж, үйл ажиллагааг зогсоох мэдээгдэл, "Сүм хийд, шашны байгууллагуудад Гамшигаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөт бус шалгалт"-г 3 аж ахуйн нэгж, байгууллагад хийж, 13 зөрчил илрүүлэн 3 зөрчлийг арилгуулж, заавал биелүүлэх албан шаардлага 2, мэдээгдэл 1-ийг хүргүүлсэн байна.

3 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх уурхайн цооногт нурал үүсч, нурлын цаана мөрөгцөгт ажиллаж байсан 25-31 насны 3 иргэний 1 нь аврагдаж, 2 нь нас барсан байсныг гаргасан байна.

2-р сард объектын гал түймрийн 8 дуудлага ирснээс гал түймрийн 6, гал түймрийн зөрчлийн 2 удаагийн дуудлагаар ажиллаж, 600 гаруй сая төгрөгийн өмч хөрөнгө авран хамгаалсан байна. Гал түймрийн дуудлагыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 38,4 хувиар буурсан байна.

**Гарсан гал**



**ГЭМТ ХЭРЭГ**

2015 оны эхний 2 сард 70 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 34,6 хувь буюу 18 хэргээр өсчээ. Гэмт хэргийн илрүүлэлт 62,5 хувьтай байна. Гэмт хэргийн улмаас 38 хүн гэмтэж осолдож, 5 хүн нас барж, төр, иргэнд 224,6 сая төгрөгийн хохирол учруулсны 18,2 хувь буюу 40,9 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ.

**Нийт бүртгэсэн гэмт хэрэг, төрлөөр:**

	Гэмт хэргийн тоо		Өсөлт, бууралт	
	2014 он	2015 он	Тоо	Хувь
Хүний амь	2	2	-	-
Хүчин	1	1	-	-
Дээрэм	-	-	-	-
Хулгай	10	14	4	40.0
Булаалт	1	1	-	-
Залилан	3	4	1	33.3
Танхай	-	4	4	-
Хүний эрх, эрх чөлөөний эсрэг	20	27	7	35.0
Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журам зөрчих	3	1	-2	-66.6
Бусад	12	16	4	33.3
<b>БҮГД</b>	<b>52</b>	<b>70</b>	<b>18</b>	<b>34.6</b>

**Нийт бүртгэсэн гэмт хэрэг, хороогоор:**

Хорооны дугаар	Нийт бүртгэсэн гэмт хэрэг		Гэмт хэргийн өсөлт, бууралт	
	2014 он	2015 он	Тоо	Хувь
1 дүгээр хороо	8	12	4	50.0
2 дугаар хороо	8	19	11	137.5
3 дугаар хороо	15	21	6	40.0
4 дүгээр хороо	8	3	-5	-62.5
5 дугаар хороо	5	5	-	-
6 дугаар хороо	4	7	3	75.0
7 дугаар хороо	4	3	-1	-25.0
<b>ДҮН</b>	<b>52</b>	<b>70</b>	<b>18</b>	<b>34.6</b>

2015 оны эхний 2 сард 3798 зөрчил илрүүлж, 3614 хүнийг 8206,0 мянган төгрөгөөр торгож, 801 хүнийг саатуулах байранд хүлээн авч, 1839,9 мянган төгрөгийг хурааж, 3 хүнийг архины албадан эмчилгээнд явуулж, 88 хүний тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасаж, 88 хүнийг шүүхээр баривчлуулсан байна.

**Гэмт хэрэг үйлдэгсэд:**

		Үүнээс: нийгмийн байдлаар					
	хүн	ХХЭрхлэгч, ажиллагсад, малчин	Төрийн албан хаагч	Оюутан сурагч	ХЦАХаагч, сургууль завсардсан хүүхэд, тэнэмэл иргэн	Малчин	Ажил- гүй
2014	39	10	1	2	2	1	23
2015	61	11	4	3	-	2	41
		Үүнээс: гэмт хэрэг үйлдэгдсэн газраар нь					
		Гудамж талбай	Гэр орон сууц	Олон нийтийн газар	Албан байгууллага, аж ахуйн нэгж	Авто замд, нийтийн тээвэр	Бусад
2014	39	4	21	5	3	3	16
2015	70	7	22	5	7	3	26
		Үүнээс: насны байдлаар нь					
	хүн	15 хүртлэх	16-24	25-34	35-44	45-59	60 дээш
2014	39	2	10	15	8	3	1
2015	61	2	10	25	15	7	2

**Өргөдөл, хүсэлтийн шийдвэрлэлт:**

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлыг бүртгэх, шилжүүлэх, шийдвэрлэх, хариу өгөх, хяналт тавих, тайлагнах ажлыг “Өргөдөл, гомдлын нэгдсэн программ”-аар явуулж байгаагийн зэрэгцээ “Налайх сонсож байна” 7023-2727 тусгай дугаарын утсаар гомдол, хүсэлт, саналыг хүлээн авч байна.

2015 оны эхний 2 сард нийт 53 санал, хүсэлт, өргөдөл хүлээн авсны 36 нь бичгээр, 2 нь утсаар, 15 нь дээд байгууллагаас ирсэн байна. Санал, хүсэлт, өргөдлийн 43-д хариу өгч, 10-д хариу өгөх хугацаа болоогүй судлагдаж байгаа ба шийдвэрлэлт 81,1 хувьтай байна.

2015 оны эхний 2 сард 32 иргэнд газрыг өмчлүүлсэн байна.

Дүүргийн Засаг даргын 10 удаагийн захирамжаар нийт 78 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын газартай холбоотой асуудлыг шийдвэрлэсэн байна.

Зориулалт	Газрын хэмжээг өөрчлөх	Газар эзэмших эрхийг сэргээх	Газар эзэмших эрх олгох	Газар эзэмших эрхийг шилжүү- лэх	Газар эзэмших эрхийг баталгаа- жуулах
Иргэн, ААНБ- ын тоо	7	1	56	13	1